



IV-VI/2022

Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18




Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого өмнөх улирлаас 74 тохиолдлоор өслөө

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2022 оны 2 дугаар улиралд 136 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 66 (94.3%), өмнөх улирлаас 74 (2.2 дахин)-өөр өссөн байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 31 (22.8%) тохиолдол унасан, бүдэрсэн, халтирснаас үүссэн бол эд зүйлд хавчуулагдсан 19 (14.0%), унаж байгаа эд зүйлд цохигдсон 11 (8.1%), гаднын халдлагад өртсөн 8 (5.9%), эд зүйл дээр гишгэсэн, суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдсон 5 (3.7%), халсан, түлэгдсэн, хөлдсөн 5 (3.7%), хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөнд өртсөн 3 (2.2%), цахилгаан гүйдэлд цохиулсан 1 (0.7%), хорт бодис, цацраг идэвхийн нөлөөнд өртсөн 1 (0.7%), бусад 52 (38.2%) тохиолдол бүртгэгдсэн байна.


Нийт осолдогчдын 47 (34.6%) нь хөнгөн хэлбэрээр, 76 (55.9%) нь хүнд хэлбэрээр осолдож, 13 (9.5%) хүн нас барсан байна.

ЗУРАГ 1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар, бүсээр



Нийт осолдогчдын 40 (29.4%) нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2022 оны 2 дугаар улиралд Төвийн бүсэд 35 (25.7%), Зүүн бүсэд 12 (8.8%), Баруун бүсэд 9 (6.6%), Хангайн бүсэд 6 (4.4%), Улаанбаатар хотод 70 (51.5%) бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2. ОСОЛДОГЧИД, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар




Осолдогчдыг насны бүлгээр авч үзэхэд 14 хүртэлх насны 3 (2.2%), 15-17 насны 1 (0.7%), 18-24 насны 16 (11.8%), 25-34 насны 44 (32.4%), 35-44 насны 39 (28.7%), 45-59 насны 31 (22.8%), 60 түүнээс дээш насны 2 (1.4%) хүн байжээ.

ХҮСНЭГТ 1. ОСОЛДОГЧИД, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Салбар	2020 IV-VI	2021 IV-VI	2022 IV-VI
Дүн	83	70	136
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2	4	3
Уул уурхай, олборлолт	17	9	30
Боловсруулах үйлдвэрлэл	7	7	12
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	2	2
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2	6	2
Барилга	11	11	16
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	-	3	2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5	4	23
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	1	1
Мэдээлэл, холбоо	2	1	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2	-	2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	-	-	3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	16	8	14
Боловсрол	1	1	10
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	10	6	6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	-	1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5	7	8

Нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр нь авч үзвэл, энгийн ажил мэргэжилтэй хүн 35 (25.7%), мэргэжилтэн 25 (18.4%), суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч 20 (14.7%), техникч болон туслах, дэд мэргэжилтэн 19 (14.0%), үйлдвэрлэл, барилга, гар урлалтай, холбоотой ажил, үйлчилгээний ажилтан 14 (10.3%), зэвсэгт хүчний ажилтан, мэргэжилтэн 10 (7.4%), контор, үйлчилгээний ажилтан 7 (5.1%), худалдаа үйлчилгээний ажилтан 3 (2.2%), менежер 2 (1.5%), хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт ан агнуурын ажилтан 1 (0.7%) байна.

ЗУРАГ 3. ОСОЛДОГЧИД, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар



Ойлголт, тодорхойлолт

Үйлдвэрлэлийн осол гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

Хурц хордлого гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

Осолдогч гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг ойлгоно.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан, иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

Бүлэг осол, хурц хордлого гэж нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно.



Эх үүсвэр:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Ангилал, код:

ISCO-08 - ажил, мэргэжлийн ангилал;

ISIC-4 - эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал;

ICD-10 - өвчний олон улсын ангилал;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 10 дугаар сарын 14

Нийгмийн статистикийн газрын
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын
Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн
статистикч Н. Алтантүлхүүр
Утас : (976-51)-265543



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212